


3.3. АШҮҮИС-ийн Эрдмийн зөвлөлийн гишүүдийн ил санал хураалтаар 75 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигчдэд “дэд профессор”, “профессор” цол олгох тогтоолыг батална.

Дөрөв. Нэр дэвшигчийн бүрдүүлэх материал

- 4.1. Төрийн албан хаагчийн 1-р маягт;
- 4.2. Ажил байдлын тодорхойлолтод нэр дэвшигчийн ажилласан жил, сургуулийн хөгжилд оруулсан хувь нэмэр, эрдэм шинжилгээ, сургалт, мэргэжлийн үйл ажиллагаанд оролцсон байдал, ёс зүйн байдлыг тусгаж, тэнхимиийн эрхлэгч хянаж, бүрэлдэхүүн сургуулийн захирал баталгаажуулна;
- 4.3. Нэр дэвшигч эрдэм шинжилгээ, судалгааны ажлын бүтээлийн жагсаалтыг үнэн зөв гаргаж, эх хувийн хамтаар бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлийн нарийн бичгийн дарга баталгаажуулна;
- 4.4. Эрдмийн цолд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийн дагуу нэр дэвшигч өөрөө бөглөсөн үнэлгээний хуудсыг тэнхимиийн эрхлэгч хянаж, бүрэлдэхүүн сургуулийн захирал баталгаажуулна;
- 4.5. Нэр дэвшигчийн тэнхимиийн хурлын протокол;
- 4.6. Бүрэлдэхүүн сургуулийн Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлж дэмжсэн хурлын тогтоол;
- 4.7. Клиникийн професорт нэр дэвшигч мэргэжлийн зөвлөх, тэргүүлэх зэргийн үнэмлэх, доктор, магистрын дипломын баталгаажуулсан хуулбар;
- 4.8. Дэд професорт нэр дэвшигч докторын дипломын баталгаажуулсан хуулбар, удирдаж хамгаалуулсан доктор, магистрын нэг сэдэвт бүтээлийн эх хувь;
- 4.9. Професорт нэр дэвшигч докторын диплом, дэд професорын үнэмлэхийн баталгаажуулсан хуулбар, удирдаж хамгаалуулсан 2-оос доошгүй докторын нэг сэдэвт бүтээлийн эх хувь;

Тав. Нэр дэвшигчийн материалд үнэлгээ хийх

- 5.1. Нэр дэвшигч өөрийн материалд үнэлгээ хийхдээ баримт бичиг, бодит байдал, нотолгоонд суурилж, үнэн зөв бөглөнө.
- 5.2. Эрдмийн цолд тавигдах үндсэн шаардлага, шалгуур 5 үзүүлэлтийг заавал биелүүлсэн байна. Үндсэн шаардлага, шалгуур үзүүлэлтийн аль нэгийг биелүүлээгүй тохиолдолд материал хүлээн авахгүй.
- 5.3. Үндсэн болон туслах шаардлага, шалгуур үзүүлэлтийн босго оноо 80 ба дээд оноо 100 хүртэл байна.
- 5.4. Нэр дэвшигч өөрийн материалд үнэлгээ хийхдээ үндсэн болон туслах шаардлагын дагуу шалгуур үзүүлэлтуүдээс нэгийг сонгож харгалзах оноог хүснэгтэд бичнэ.
- 5.5. Нэг үзүүлэлтийг давхардуулж үнэлэхгүй.



“АШУУИС-ийн Эрдмийн цол олгох
журам”-ын нэгдүгээр хавсралт

Клиникийн профессор цолд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт

д/д	Үндсэн шаардлага, шалгуур (заавал биелүүлэх)	Болзол хангасан эсэх	Харгалзах оноо
1	АШУУИС-д гэрээт, эсвэл үндсэн ба төрөлжсөн мэргэшлийн сургалт эсвэл оюутны зуны, үйлдвэрлэлийн дадлага 5-аас доошгүй жил удирдсан байх	Хангасан (15)	
		Хангаагүй (0)	
2	Мэргэжлийн тэргүүлэх зэрэг хамгаалсан байх	Хангасан (15)	
		Хангаагүй (0)	
3	Магистр ба түүнээс дээш эрдмийн зэрэгтэй байх	Хангасан (15)	
		Хангаагүй (0)	
4	Оношилгоо эмчилгээний заавар, шинэ арга технологи 5-аас доошгүйг нэвтрүүлсэн байх	Хангасан (15)	
		Хангаагүй (0)	
5	Мэргэжлийн сэтгүүлд 2-оос доошгүй өгүүлэл нийтлүүлсэн байх	Хангасан (15)	
		Хангаагүй (0)	
Туслах шаардлага, шалгуур			Харгалзах оноо
6	Ном, гарын авлага, зөвлөмж, товхимол, аргачлал зэргийг 2-оос доошгүйг хэвлүүлсэн байх	Хангасан (5)	
		Хангаагүй (0)	
7	Нийтэд зориулсан нийтлэл, өгүүлэл, зөвлөмж 3-аас доошгүйг нийтлүүлсэн байх	Хангасан (5)	
		Хангаагүй (0)	
8	Зохиогчийн эрх, ашигтай загвар 2-оос доошгүйг авсан байх	Хангасан (5)	
		Хангаагүй (0)	
9	Гадаад, дотоодын эрдэм шинжилгээний хуралд 10-аас доошгүй илтгэл хэлэлцүүлсэн байх	Хангасан (5)	
		Хангаагүй (0)	
10	Мэргэжлийн болон эрүүл мэндийн боловсролын чиглэлээр нийтэд зориулсан 10-аас доошгүй сургалтад оролцсон, зохион байгуулсан байх	Хангасан (5)	
		Хангаагүй (0)	

Зааварчилгаа: Босго оноо 80.

Бөглөхдөө үндсэн болон туслах шаардлагын дагуу харгалзах оноог хүснэгтэд бичнэ.